

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2019.09.30

Тосонцэнгэл сум
Дархан-Уул баг

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн ИНЕГ-ын харьяа Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/22 тоот удирдамжийн хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймаг дахь Тосонцэнгэл нисэх буудлын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга аван ажиллалаа.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь нисэх буудлын 2015-2018 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, эмхлэлт, цэгцлэлт сайн байна.

Хамт олны хоорондын харилцаа найрсаг, зөрчилдөөнгүй. Удирдлагын хувьд санаачилгатай, бүтээлч, залуу боловсон хүчин байна.

Өртөг зардал хэмнэх, өөрсдийн нөөц бололцоог ашиглах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж санаачилгатай ажиллаж байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор нийт 5 хүнд илүү олгосон.

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, үдэлт цэгцлэлт сайн, архив бичиг хэргийн хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөж ажилладаг байна.

2017 оноос 2019 оны 1 дүгээр улирлын дуусталх хугацаанд шилэн дансны цахим хуудасны хөтлөлттэй холбоотой хугацаа хоцроох, хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрийг байршуулаагүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажиллахад анхаарч, хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх шаардлагатай.

Батлагдсан төсвөөр жил бүр галлагааны модны худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2.-т заасан ...шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар..., Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах” тухай 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийг тогтмол давсан боловч хууль болон журмыг мөрдөж ажиллаагүй, шууд гэрээ байгуулсан байна.



Нисэх буудлын 2017-2019 онд байгуулсан гэрээнд гэрээ байгуулсан огноог огт тавиагүй, огноог буруу бичсэн, гэрээ байгуулсан хүний нэр албан тушаалын тайллыг бичээгүй, зарим гэрээг дугаарлаагүй зэрэг зөрчлүүд байгаад анхаарч ажиллах хэрэгтэй.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авах талаар 13 зөвлөмжийг хүргүүлсэн.

ДОТООД АУДИТЫН АЛБА